152

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ
14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2024.11.11 № 34.

МОНГОЛ УЛСЫН ХОТ БАЙГУУЛАЛТ,
БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН
САЙД Ж.БАТСУУРЬ ТАНАА

Улаанбаатар хотын усны
чанарын тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуултыг тавьж байна. Үүнд:

1. Улаанбаатар хотын усны чанар, хатуулгийн үзүүлэлтүүд одоогийн байдлаар ямар түвшинд байгаа вэ? Сүүлийн 5 жилийн харьцуулсан статистик мэдээлэл
2. Усны чанар, хатуулгийн үзүүлэлтүүд иргэдийн эрүүл мэнд, өвчлөлд хэрхэн нөлөөлж байгаа талаар хийгдсэн судалгаа байгаа эсэх? Хэрэв байгаа бол уг судалгааны үр дүнгийн товч танилцуулга.
3. Улаанбаатар хотын ундны усны чанарт ямар стандартуудыг мөрддөг вэ? Эдгээр стандартууд олон улсын жишигт нийцэж байгаа эсэх?
4. Улаанбаатар хотын усны чанарыг сайжруулах, хатуулгийг бууруулах чиглэлээр хийгдэж буй ажлуудын үр дүнг хэрхэн хэмжиж, үнэлж байгаа вэ?
5. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар дугаар зүйлийн 2-т заасан иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй гэсэн заалтыг хэрэгжүүлэх үүднээс хотын усны чанарыг сайжруулах, хатуулгийг бууруулах чиглэлээр цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээ, төсөл хөтөлбөр байгаа эсэх? Хэрэв байгаа бол тэдгээрийн товч танилцуулга, хэрэгжих хугацаа, хүрэх үр дүнгийн талаар мэдээлэл зэрэг болно.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т заасан хугацаанд ирүүлнэ үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН: С.ЭРДЭНЭБОЛД

2024000073